

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2023/13-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: З.Золбоо Утас: 70362442 Цахим хаяг: zolbooz@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
4. Аудитын тайлан	20
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.2 Материаллаг байдал.....	20
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	24
5. Аудитын илрүүлэлт	25
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил , үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ТҮШИГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.БАТБОЛД ТАНАА

2023.03.25 № СЭА-2023/13-НА-СА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан, хандив тусламжийн орлогыг сумын ОНХС-ийн дансанд төвлөрүүлээгүй, биетээр оршоогүй хөрөнгийг бүртгэл тайланд тусгасан, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 60 дугаар зүйлийн 60.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, 15.2.3, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтууд болон Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын

1 дүгээр хавсралт, 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Түшиг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 80.3 хувьтай тайлагнагдсан, батлагдсан төсвийг 19.7 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ЭМТ, соёлын төв нь тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд шилжсэнээр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	888,742.9	1,350,843.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	426,120.7	1,029,849.8
33	АВЛАГА	198,762.4	239,731.1
35	БАРАА МАТЕРИАЛ	263,859.8	81,262.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,606,181.2	1,167,369.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,606,181.2	1,167,369.9
39200	Биет хөрөнгө	4,485,974.0	1,100,258.5
39300	Биет бус хөрөнгө	120,207.2	67,111.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,494,924.1	2,518,212.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	667.1	14,759.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	667.1	14,759.7
41300	Өглөг	667.1	14,759.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,494,257.0	2,503,453.2
51	Засгийн газрын хувь оролцоо	5,494,257.0	2,503,453.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,873,329.3	351,845.2
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	-	351,845.2
51200	Хуримтлагдсан үр дүн	2,443,295.8	1,921,601.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,177,631.9	230,006.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,494,924.1	2,518,212.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,277,996.80	1,873,384.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	352,928.40	648,442.20
110	Орлогын албан татвар	33,191.40	147,600.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	33,191.40	147,600.50
113	Хөрөнгийн албан татвар	46,364.00	29,790.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	273,373.00	471,051.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	706,766.80	217,632.20
120	Нийтлэг татварын бус орлого	706,766.80	217,632.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,218,301.70	1,007,309.90
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,455,348.50	875,642.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,455,348.50	875,642.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,351,159.40	828,600.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,369,097.90	308,331.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,672.70	41,076.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	222,345.60	245,053.70
2104	Хангамж, бараа материалын зардал	63,294.70	37,949.40
2105	Нормативт зардал	129,830.30	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,286.30	23,750.00

2107	Томилолт, зочны зардал	3,341.90	9,219.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,519.70	5,187.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	344,770.20	158,032.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,189.10	47,041.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	822,648.40	997,741.80
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	204,498.30	3,975,969.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	618,150.10	-2,978,227.50

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-рх үлдэгдэл	4,877,271.00	-	4,877,271.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-405	-	-405
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,876,866.00	-	4,876,866.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
5	Тайлант үеийн үр дүн	617,391.10	-	617,391.10
6	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,494,257.00	-	5,494,257.00
7	2022 оны 1-р сарын 1-рх үлдэгдэл	5,494,257.00	-	5,494,257.00
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-12,576.40	-	-12,576.40
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,481,680.70	-	5,481,680.70
10	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
11	Тайлант үеийн үр дүн	-2,978,227.50	-	-2,978,227.50
12	2022 оны 12-р сарын 31-рх үлдэгдэл	2,503,453.20	-	2,503,453.20

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,644,206.40	1,855,767.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	352,928.40	648,442.20
110	Орлогын албан татвар	33,191.40	147,600.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	33,191.40	147,600.50
113	Хөрөнгийн албан татвар	46,364.00	29,790.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	273,373.00	471,051.40
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,415.30	4,941.30
1181	Газрын төлбөр	40	33,347.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	264,917.60	432,763.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	78,110.20	200,015.40
120	Нийтлэг татварын бус орлого	78,110.20	200,015.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,213,167.90	1,007,309.90
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,175,400.20	750,553.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,175,400.20	750,553.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,069,109.00	702,592.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,368,210.20	308,481.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	179,877.60	41,226.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	222,419.40	245,053.70
2104	Хангамж, бараа материалын зардал	46,605.80	35,635.60
2105	Нормативт зардал	150,826.30	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,763.00	23,750.00
2107	Томилолт, зочны зардал	3,341.90	9,219.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,739.30	6,666.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,325.50	32,558.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,291.20	47,961.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	468,806.20	1,105,214.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	253,658.80	423,485.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	253,658.80	423,485.00
2200	Дотоод эх үүсвэрээр	253,658.80	423,485.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-253,658.80	-423,485.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-57,000.00	-78,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	57,000.00	78,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	158,147.40	603,729.10
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	267,973.30	426,120.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	426,120.70	1,029,849.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,283,252.20	1,029,961.73	253,290.47	80.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	893,691.90	787,137.71	106,554.19	88.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	834,188.80	740,095.80	94,093.00	88.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	335,750.50	306,745.71	29,004.79	91.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,654.40	41,226.15	428.25	98.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	301,094.50	245,053.67	56,040.83	81.39
2104	Хангамж, бараа материалын зардал	33,186.20	32,241.11	945.09	97.15
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	70,593.90	67,384.15	3,209.75	95.45
2107	Томилолт, зочны зардал	10,395.40	9,219.80	1,175.60	88.69
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,347.00	6,666.71	2,680.29	71.32
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,166.90	31,558.50	608.40	98.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,503.10	47,041.91	12,461.19	79.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,503.10	47,041.91	12,461.19	79.06
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	310,781.50	164,824.02	145,957.48	53.04
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	78,778.80	78,000.00	778.80	99.01
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,283,252.20	1,077,474.10	205,778.10	83.96
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,172,823.80	1,015,798.11	157,025.69	86.61
320001	Орон нутгийн төсвөөс	971,970.70	814,945.01	157,025.69	83.84
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	200,853.10	200,853.10	-	100.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	110,428.40	61,675.98	48,752.42	55.85
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	80,500.00	60,425.88	20,074.12	75.06

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	324,878.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	109,851.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,130.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,736.00
210104	Урамшуулал	1,736.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,394.52
210401	Бичиг хэрэг	583.00
210402	Тээвэр, шатахуун	2,781.52
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,721.43
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	103,721.43
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	103,721.43
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	215,026.74
2200	Дотоод эх үүсвэрээр	215,026.74
221001	Их засвар	215,026.74
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	324,878.69
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	324,878.69
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,476.32
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	321,989.37
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	413.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Түшиг сумын ТТЗ нь үйл ажиллагааны эрхэм зорилгыг *“Ирээдүй нь гэрэлтэй, Иргэд нь жаргалтай сум болохын төлөө”* гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах гэх мэт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.

- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2022 оны 194 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт”-д өөрчлөлт оруулсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.
- ХХААХҮС-ын 2021 оны А/361 дугаар тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлтэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам” хэрэгжиж ирсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт нь оновчтой боловч хэрэгжилт үр нөлөө муутай гэж үзлээ. Тайлант онд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түшиг сумын ТТЗ-ийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Түшиг сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Түшиг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,976,711.3 мянган төгрөгөөр буюу 45.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	426,120.7	1,029,849.8	603,729.1
Авлага	198,762.4	239,731.1	40,968.7
Бараа материал	263,859.8	81,262.0	(182,597.8)
Үндсэн хөрөнгө	4,606,181.2	1,167,369.9	(3,438,811.3)
Нийт хөрөнгө	5,494,924.1	2,518,212.8	(2,976,711.3)
Өр төлбөр	667.1	14,759.7	14,092.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,494,257.0	2,503,453.1	(2,990,803.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,494,924.1	2,518,212.8	(2,976,711.3)

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансуудын өөрчлөлтийг авч үзэхэд дараах байдалтай байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 426,120.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 1,029,849.8 мянган төгрөг болж, 603,729.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	426,120.7	1,029,849.8	603,729.1
Төрийн сангийн харилцах	426,120.7	1,029,849.8	603,729.1
Дүн	426,120.7	1,029,849.8	603,729.1

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан 881,266.0 мянган төгрөг ОНХО-ын дансанд, 105,457.0 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 28,494.2 мянган төгрөг ХХС-ийн дансанд, 14,632.6 мянган төгрөг барьцаа хөрөнгийн дансанд тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 198,762.3 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 239,731.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 40,968.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	-	149.6	149.6
Татаас, санхүүжилтийн авлага	11,595.5	-	(11,595.5)
Зээлийн хүүгийн авлага	2,195.1	3,027.2	832.1
Байгууллагаас авах авлага	12,311.3	43,061.6	30,750.3
Хувь хүмүүсээс авах авлага	2,464.4	2,464.4	-
Зээлийн авлага	170,196.0	191,028.3	20,832.3
Дүн	198,762.3	239,731.1	40,968.8

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 63,096.0 мянган төгрөгийн авлага байна. Үүнд:

- ОНЕО-ын дансанд бүртгэлтэй 2010-2011 онд 5 иргэнд олгосон итгэлийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 2,464.4 мянган төгрөг /тооцоо нийлсэн акт байхгүй, зээн тодорхойгүй/,
- ОНХС-ийн дансанд 2013 онд тус сангийн эх үүсвэрээр хийгдэхээр төлөвлөгдсөн “Цэцэрлэгийн барилгын засвар”-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Баатар булаг” ХХК-д 6,000.0 мянган төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн боловч ажил огт хийгдээгүйгээс үүссэн /шүүхэд шилжүүлсэн боловч эцэслэж шийдвэрлэгдээгүй/,
- ХХС-ийн дансанд 2011-2020 онуудад олгосон эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн авлагын нийт 54,631.6 мянган төгрөг зэрэг авлагууд бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт

- Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн авлагад 191,028.3 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байгаагаас 2011-2018 онд олгосон 16 иргэний **54,631.6** мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулахаар холбогдох шатны шүүхэд хандаж шийдвэрлүүлээгүй, зээлдэгчдэд мэдэгдэх хуудас өгөөгүй буюу зээлийг эргэн төлүүлэх талаар үр нөлөө бүхий арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй,
- Тайлант онд ХХС-аас олгосон Баялаг Зэлтэр, Өгөөмөр түшиг өндөр хайрхан хоршоодод олгосон нийт **76,000.0** мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэх ажлын хэсэг байгуулаагүй, барьцаа хөрөнгө зээлийн дүнд хүрсэн эсэхийг үнэлэлгүйгээр олгосон байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 263,859.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 81,262.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 182,597.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	36,858.7	-	(36,858.7)
Тусгай зориулалттай материал	28,093.1	-	(28,093.1)
Эм боох материал	8,765.7	-	(8,765.7)
Бэлэн бүтээгдэхүүн	2,054.6	-	(2,054.6)
Хангамжийн материал	224,716.4	81,032.0	(143,684.4)
Аж ахуйн материал	164,026.0	80,392.6	(83,633.4)
Түлш, шатах тослох материал	937.3	639.5	(297.8)
Хүнсний материал	6,205.0	-	(6,205.0)
Бусад хангамжийн материал	53,548.1	-	(53,548.1)
Мал амьтад	230.0	230.0	-
Дүн	263,859.7	81,262.0	(182,597.7)

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь нийт 225,722.3 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 13,200.0 мянган төгрөгийн материалыг шилжүүлэн авсан болон 112,175.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 119,445.1 мянган төгрөгийн материалыг шилжүүлж, бүтцийн өөрчлөлтөөр 188,784.7 мянган төгрөгийн материалыг данс бүртгэлээс хасан, 1,115.0 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгаснаас голлон шалтгаалсан байна.

Тайлант онд сумын боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн тайлан харьяалах яамдын төсвийн ерөнхийлөөн захирагчдын санхүүгийн тайланд нэгтгэгддэг болсноос шалтгаалж бараа материалын дансны үлдэгдэл буурсан байна.

Аудитын илрүүлэлт

- Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй тайлант онд бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй нийт **25,078.3** мянган төгрөгийн /ИТХ нь 5,594.7 мянган төгрөг, ЗДТГ нь 19,483.6 мянган төгрөг/ зөрчлийг давтан гаргасан,
- Мал амьтад дансанд бүртгэлтэй **230.0** мянган төгрөгийн өртөг бүхий адуу нь биетээр оршин байхгүй /хорогдсон гэх/ боловч үлдэгдлээр тайлагнасан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,417,861.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,627,350.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,790,511.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	5,294,606.8	1,558,154.2	(3,736,452.6)
Барилга, байгууламж, орон сууц	3,349,922.3	595,521.6	(2,754,400.7)
Авто-тээврийн хэрэгсэл	232,595.1	65,932.6	(166,662.5)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	546,341.4	112,531.3	(433,810.0)

Тавилга, аж ахуйн эд хогшил	194,825.1	31,230.5	(163,594.6)
Зам, гүүрийн байгууламж	159,465.4	90,710.4	(68,755.0)
Бусад үндсэн хөрөнгө	693,190.3	662,227.8	(30,962.5)
Дуусаагүй барилга, байгууламж	83,356.4	-	(83,356.4)
Ном	34,910.8	-	(34,910.8)
Биет бус хөрөнгө	123,254.8	69,195.8	(54,059.0)
Программ хангамж	6,900.0	3,450.0	(3,450.0)
Бусад биет бус хөрөнгө	116,354.8	65,745.8	(50,609.0)
Дүн	5,417,861.6	1,627,350.0	(3,790,511.6)

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 3,790,511.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 43,634.2 мянган төгрөг, ОНХС-аас 76,245.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан болон 29,203.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, бүтцийн өөрчлөлтөөр 3,881,186.9 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хассан зэргээс шалтгаалсан байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 667.1 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 14,759.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 14,092.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	517.1	14,759.7	14,242.6
Хувь хүмүүст төлөх өглөг	150.0	-	(150.0)
Дүн	667.1	14,759.7	14,092.6

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь барьцаа хөрөнгийн дансанд 14,759.7 мянган төгрөг /Монгол ЛС зам гүүр ХХК-ий/ байршуулснаас шалтгаалсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,494,257.0 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 2,503,453.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,990,803.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	1,873,329.3	351,845.2	(1,521,484.1)
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,873,329.3	351,845.2	(1,521,484.1)
Хуримтлагдсан үр дүн	2,443,295.8	1,921,601.2	(521,694.6)
Өмнөх үеийн үр дүн	1,825,904.7	4,899,828.7	3,073,924.0
Тайлант үеийн үр дүн	617,391.1	(2,978,227.5)	(3,595,618.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,177,631.9	230,006.7	(947,625.2)
Дүн	5,494,257.0	2,503,453.2	(2,990,803.8)

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,990,803.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүн буурснаас шалтгаалсан байна.

3.4.7 Зардлын данс

Зардлын данстай холбоотой **105,676.5** мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд: **Аудитын илрүүлэлт:**

Төсвийн төвлөрүүлэн захирагч

- ТТЗ нь Шар нарст ХХК-ийн нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд олгосон **25,000.0** мянган төгрөгийн хандивыг ОНХС-ийн дансанд бус Мандах Зэлтэр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын дансанд төвлөрүүлж, зарцуулсан,

Иргэдийн Төлөөлөгчийн Хурал

- ИТХ-ын даргын тайлант оны 14 дүгээр захирамжаар нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн арга хэмжээнд **6,035.2** мянган төгрөгийг зарцуулсан,
- Анхан шатны баримтын бүрдэлгүй буюу **2,367.4** мянган төгрөгийн шатахууны зардлыг жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн эхний, эцсийн заалтыг гүйцэтгэлээр бүртгэлгүйгээр батлагдсан маршрутын километрээр хянаагүй, бөөн дүнгээр бүртгэсэн байна.

Засаг даргын Тамгын газар

- ЗДТГ-ын даргын тайлант оны А/30 дугаар тушаалаар “Төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх” сургалтад албан хаагчдыг Улаанбаатар хотод сургалтад хамруулахад **4,612.7** мянган төгрөгийн зардал гаргасан,
- Өмнөх онд өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу албан хаагчдын илүү цагийн нэмэгдэл хөлсний тооцоог “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-аар баталгаажуулалгүйгээр **3,400.7** мянган төгрөгийг олгосон,
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хамаарах уралдаан, тэмцээн, арга хэмжээ зохион байгуулахад нийт **25,591.6** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- Өмч хамгаалах зөвлөлөөр автомашинд засвар, үйлчилгээ зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаарх техникийн комиссын дүгнэлт гаргалгүйгээр **10,413.3** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл, тайланд тусгасан,
- Анхан шатны баримтын бүрдэлгүй буюу **28,255.6** мянган төгрөгийн шатахууны зардлыг жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн эхний, эцсийн заалтыг гүйцэтгэлээр бүртгэлгүйгээр батлагдсан маршрутын километрээр хянаагүй, бөөн дүнгээр бүртгэсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн татварын болон татварын бус орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын 2022 оны орон нутгийн төсөв батлах тухай 2022 оны 49 дүгээр тогтоолоор тайлант онд 261,912.5 мянган төгрөгийн татварын орлого, 15,500.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 772,538.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 2.8 дахин давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого	115,000.0	121,471.9	(6,471.9)	105.6
Үйл ажиллагааны орлого	4,400.0	14,549.0	(10,149.0)	3.3 дах
Хөрөнгийн орлого	9,000.0	8,499.4	500.6	94.4
Хөрөнгө борлуулсны орлого	6,000.0	3,080.0	2,920.0	51.3
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	10,000.0	5,754.3	4,245.7	57.5
Бууны албан татвар	1,500.0	2,245.0	(745.0)	149.7
Малд ногдуулах албан татвар	-	21,791.0	(21,791.0)	-
Улсын тэмдэгтийн хураамж	4,000.0	2,886.2	1,113.8	72.2
Түгээмэл тархацтай АМ ашигласны төлбөр	500.0	2,055.0	(1,555.0)	4.1 дах
Газрын дуудлага худалдаа	26,981.0	33,347.0	(6,366.0)	123.6
Газрын төлбөр	9,264.0	-	9,264.0	-
Ойн нөөц ашигласны төлбөр	70,861.5	111,089.3	(40,227.8)	156.8
Агнуурын нөөц ашигласны төлбөр	2,486.0	1,240.0	1,246.0	49.9
Байгалийн ургамал ашигласны төлбөр	1,920.0	320,433.9	(318,513.9)	166 дах
Бусад орлого	3,000.0	114,203.4	(111,203.4)	38.1 дах
Түрээсийн орлого	2,500.0	1,814.4	685.6	72.6
Торгуулийн орлого	10,000.0	8,079.1	1,920.9	80.8
Нийт дүн	277,412.5	772,538.9	495,126.4	278.45

Эх сурвалж: Түшиг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд хувь хүний орлогын албан татвар 6,471.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 10,149.0 мянган төгрөг, малын хөлийн албан татвар 21,791.0 мянган төгрөг, ойн нөөц ашигласны төлбөр 40,227.8 мянган төгрөг, бусад орлого 111,203.4 мянган төгрөгөөр тус тус давсан нь голлон нөлөөлсөн бол үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 4,245.7 мянган төгрөг, газрын төлбөр 9,264.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давсан орлого

- Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааны орлого нэмэгдсэнээс шалтгаалж хувь хүний үйл ажиллагааны орлогод ногдох татвар хураамж 10,149.0 мянган төгрөгөөр давсан,

- Тайлант онд цалин хөлс өссөнөөс шалтгаалж хувь хүний орлогын албан татвар орлого 6,471.9 мянган төгрөгөөр давсан,
- Ойн нөөц ашигласны төлбөр 40,227.8 мянган төгрөгөөр давж биелсэн нь тайлант онд ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээ нэмэгдсэн болон Шинэбадрах ХХК-ийн хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр /2021 оны мод бэлтгэх зөвшөөрлөөр тус онд бэлтгэсэн талбайн /-ийг төлснөөс шалтгаалсан,
- Байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлого 318,513.9 мянган төгрөгөөр давсан нь тайлант онд тус суманд жимс их хэмжээгээр ургаж, хуш модны самрыг ахуйн болон үйлдвэрлэлийн зорилгоор түүх зөвшөөрлийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад олгосноос шалтгаалсан,
- Бусад орлого 111,203.4 мянган төгрөгөөр давж биелсэн нь Татварын Ерөнхий газраас 2014-2020 онд “Рэдхилл Монголиа” ХХК-нд ногдуулсан рашаан ус ашигласны төлбөрийн өглөгийг орон нутгийн дансанд шилжүүлсэн,
- Малын тоо толгойн албан татвар 21,791.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь ИТХ-ын батлагдсан төсвийн төлөвлөгөөнд орлого тусгаагүйгээс тус тус шалтгаалсан байна.

Тасарсан орлого

- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 4,245.7 мянган төгрөгөөр тасарсан нь тайлант онд иргэн, аж ахуйн нэгж байгууллагын нэр дээрх үл хөдлөх хөрөнгийн борлуулалт буурснаас,
- Газрын төлбөр 9,264.0 мянган төгрөгөөр тасарсан нь Түшиг сум нь хилийн зурвас газарт харьяалагддаг учир газрын төлбөрөөс чөлөөлөгддөгөөс өөрөөр хэлбэл үндэслэлгүй төлөвлөлтөөс шалтгаалсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагыг 1,364,669.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийг сумын ИТХ-ын 2021 оны 30 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 297,412.5 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 542,995.2 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 200,853.1 мянган төгрөг, ОНХС-ын урьд оны үлдэгдлээс 69,928.4 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлт 80,000.0 мянган төгрөг, сумын төсвийн урьд оны үлдэгдлээс 172,980.2 мянган төгрөг, төсвийн байгууллагын өөрийн орлогоос 500.0 мянган төгрөг зэрэг нийт **1,364,669.4** мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 49 дүгээр тогтоолоор дараах өөрчлөлтийг оруулан төсвийн орлого, зарлагыг бууруулж **1,283,252.2** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 61,417.2 мянган төгрөгөөр, цалин хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогыг 20,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж тодотгосон,

- ТЗШ-ийн байгууллагуудад олгох тогтмол зардлын санхүүжилтийг 95,291.3 мянган төгрөгөөр, Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг 10,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, ЗДТГ-ын урсгал зардлыг 23,874.1 мянган төгрөгөөр *Ихангамж бараа материалын зардлыг 15,874.1 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 1,000.0 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 7,000.0 мянган төгрөгөөр* нэмэгдүүлэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор төсвийн орлого, зарлагыг 81,417.2 мянган төгрөгөөр бууруулж 1,283,252.2 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 11 *ИТХ 2, ЗДТГ7, ОНХС 1, ХХС 1* хөтөлбөрийн 28 *ИТХ 6, ЗДТГ 17, ОНХС 3, ХХС 2* арга хэмжээг санхүүжүүлэхээр 481,578.1 мянган төгрөгийг аймгийн төсвөөс, 200,853.1 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 172,980.1 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 69,928.4 мянган төгрөгийг ОНХС-ийн эхний үлдэгдлээс, 80,000.0 мянган төгрөгийн ХХС-ийн эргэн төлөлтөөс, 277,412.5 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, нийт **1,283,252.2** мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 481,578.1 мянган төгрөгийг аймгийн төсвөөс, 200,853.1 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 55,954.4 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 28,617.4 мянган төгрөгийг ОНХС-ийн эхний үлдэгдлээс, 59,925.9 мянган төгрөгийн ХХС-ийн эргэн төлөлтөөс, 772,538.9 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос нийт **1,599,967.8** мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,029,961.7 мянган төгрөг буюу 80.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 203,811.0 мянган төгрөгөөр, боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагад олгох тогтмол зардлын санхүүжилтийг 49,479.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 321,989.4 мянган төгрөг *аймгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс хэрэгжүүлэх “ЭМТ-ийн барилгын өргөтгөлийн их засвар”, “Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг” хийх төсөл, арга хэмжээний санхүүжилт 1,* аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,476.3 мянган төгрөг, үндсэн

үйл ажиллагааны хүрээнд бий болсон 413.0 мянган төгрөгийн нэмэлт орлогыг тус тус бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 1,736.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 3,394.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,000.0 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 103,721.4 мянган төгрөг, 215,026.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түшиг сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах шатахуун зарцуулалтын гүйцэтгэлийг жолоочийн тооцооны хуудсаар хянах, анхан шатны баримтад үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэх, ХХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах, зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэх ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн ХХС-аас зээл олгож байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Золбоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Түшиг сумын ТТЗ-ийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 1/30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тус ТТЗ-ийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,455,348.5 мянган төгрөгөөс 1.5

хувиар буюу 36,830.2 мянган төгрөгөөр тогтоосныг төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн тайлан харьяа яамдад нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал дүн болох 1,690,587.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон **25,358.8** мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/633 дугаар албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, өр авлага үүсгэхгүй ажиллах, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, ТБОНӨХБАҮХА тухай хууль болон босго үнийн журмыг мөрдөн ажиллах, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах гэх мэт нийт 18 төрлийн чиглэлийг хүргүүлсэн байна.

Түшиг сумын ТТЗ нь батлагдсан төсвийг 19.7 хувиар хэмнэсэн болон бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашиглаж, бичиг хэргийн зардлыг хэмнэж ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хамаарах 46 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтуудыг зөрчсөн нийт 10,647.9 мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргын тайлант оны 14 дүгээр захирамжаар нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн арга хэмжээнд 6,035.2 мянган төгрөгийг зарцуулсан,
- Сумын ЗДТГ-ын даргын тайлант оны А/30 дугаар тушаалаар “Төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх” сургалтад албан хаагчдыг Улаанбаатар хотод сургалтад хамруулахад 4,612.7 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.3: үр ашигтай байх”, 4.2.2 дахь “Хэмнэлтийн горим нь иргэд, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж, тэдний дэмжлэгийг хүлээхүйц түвшинд тодорхойлогдсон байх”, 12 дугаар зүйлийн 12.1 дэх “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.3 дэх “хэвлэлийн захиалгын төлбөр” 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.2 дахь “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.3:

“сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 10. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	168	123	45
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	171	127	44
3	Засаг даргын Тамгын газар	171	141	30
	Нийт дүн	510	391	119

Эх сурвалж: www.old.shilendans.gov.mn

ТТЗ болон харьяа байгууллагууд нь мэдээлбэл зохих 510 мэдээллээс 391 мэдээллийг хугацаанд нь, 119 мэдээллийг хугацаа хоцроож, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.2 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэж заасныг үндэслэн ТТЗ-ийн Санхүүгийн албаны дарга Б.Батдэлгэрт сахилгын шийтгэл ногдуулах, албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайлант онд сумын ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр нийт 255,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл арга хэмжээг зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгааг урьдчилан хийлгүйгээр сумын ИТХ-аар баталсан бөгөөд батлагдсан төсөвт өртөгт нь багтааж тендер, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.1.3 дахь “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг урьдчилан хийсний үндсэн дээр баталж, хэрэгжүүлэх албан шаардлага өгөх.

2. Байгууллагын урсгал зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамааралгүй 8,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Мэргэжлийн ангийг чадваржуулах" төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.1: “Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ”, 60.4 дэх “Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ОНХС-ийн хөрөнгөөр зориулалт бус төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхгүй байх албан шаардлага өгөх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 142,892.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 747.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 12,537.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэн, 129,606.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 7 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	747.4	1	747.4	100.0
Албан шаардлага	2	12,537.7	2	12,537.7	100.0
Зөвлөмж	7	129,606.9	4	22,385.3	57.1
Нийт дүн	10	142,892.0	7	35,670.4	70.0

Өмнөх аудитаар өгсөн төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар төлөвлөж, хэрэгжүүлж байх, албан хаагчдын илүү цагийн нэмэгдэл хөлсний тооцоог “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-аар баталгаажуулж олгох, бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж байх гэсэн 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан байна.

Дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг шалгаж амжаагүй тул Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46,304.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс 43,634.2 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй 2,670.0 мянган төгрөгийн алдааг цаашид арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв. Үүнд:

- ИТХ нь 17,150.0 мянган төгрөгийн, ЗДТГ нь 26,484.2 мянган төгрөгийн багаж, техник хэрэгслийн зардлаас хөрөнгө худалдаж авсан ажил гүйлгээг төсвийн гүйцэтгэлийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд дутуу илэрхийлснийг залруулсан.
- Засаг даргын нөөц хөрөнгийн эх үүсвэрээс сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан хэвлүүлсэн 2,670.0 мянган төгрөгийн зардлыг холбогдох тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэж, тайлагнасан алдааг залруулаагүй алдаагаар тооцсон.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.21-дэх "Бараа материалыг (хангамжийн зүйлийг) худалдан авсан үед дт-хангамжийн материал, кт-мөнгөн хөрөнгө/дансны өглөг, (г) Бараа материалыг ажил үйлчилгээнд ашиглахаар тавьж олгоход: Дт. Зардал /Зардлын зүйлээр/ Кт. Хангамжийн материалын холбогдох дэд данс" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Бараа материалын тооцооны дансаар дамжуулан бүртгэж байх зөвлөмж өгөв.

Аудитаар нийт 261,616.4 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 89,948.5 мянган төгрөгийн 8 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 171,667.9 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн.

Албан шаардлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

5.1.1 ТТЗ нь Шар нарст ХХК-ийн нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд олгосон **25,000.0** мянган төгрөгийн хандив, тусламжийг ОНХС-ийн дансанд бус Мандах Зэлтэр тохижилт үйлчилгээ ААТҮГ-ын дансанд төвлөрүүлж зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь "Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 60.2.5.тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, ..." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сум, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор өгсөн хандив, тусламжийг сумын ОНХС-ийн дансанд төвлөрүүлж, холбогдох хууль, журмын хүрээнд зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

5.1.2 Нэг удаагийн тэтгэмж урамшууллын батлагдсан төсвөөс нутгийн өөрөө удирдах байгууллага үүсэж хөгжсөний 30 жилийн ойн арга хэмжээнд /850.0 мянган төгрөгийг гарын бэлэг, 2,785.2 мянган төгрөгийг зочин төлөөлөгч хүлээн авахад, 2,400.0 мянган төгрөгийг албан хаагчдад биеийн тамирын хувцас авахад/ нийт **6,035.2** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-дэх” Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.5: “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”, 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшил: “Байгууллагын дотоод журамд заасны дагуу **албан хаагчид голдуу хагас болон бүтэн жилийн эцэст нэг удаа олгох** мөнгөн шагнал, урамшуулал, эсхүл журамд заасан нөхцөлөөр олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардал энд хамаарна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

Засаг даргын Тамгын газар:

5.1.3 ЗДТГ-ын даргын тайлант оны А/30 дугаар тушаалаар “Төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх” сургалтад албан хаагчдыг Улаанбаатар хотод сургалтад хамруулахад **4,612.7** мянган төгрөгийн зардал гаргасан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”, 15.2.3: “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5.1.4 Мал амьтад дансанд **230.0** мянган төгрөгийн өртөг бүхий адуу биетээр оршин байхгүй /хорогдсон гэх/ боловч бүртгэл тайланд үлдэгдэлтэй тайлагнагдаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Оршин байхгүй малын хорогдсон шалтгааныг тогтоож, данс бүртгэлээс хасах албан шаардлага хүргүүлэв.

5.1.5 Өмнөх онд өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан:

- ЗДТГ нь нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд батлагдсан төсвөөс албан хаагчдын сургалтын зочид буудлын зардал, мал тооллогын

шатахууны зардал, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хамаарах уралдаан, тэмцээн, арга хэмжээ зохион байгуулах зэрэгт нийт **25,591.6** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,

- Бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй нийт **25,078.3** мянган төгрөгийн /ИТХ нь 5,594.7 мянган төгрөг, ЗДТГ нь 19,483.6 мянган төгрөг/ худалдан авалтыг гүйцэтгэж бүртгэл тайланд тусгасан,
- ЗДТГ нь албан хаагчдын илүү цагийн нэмэгдэл хөлсний тооцоог “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-аар баталгаажуулалгүйгээр **3,400.7** мянган төгрөгийг олгосон байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3.4 дэх “... Ажлын товч агуулга гэсэн хэсэгт нэмэгдэл хөлс тооцох цагт гүйцэтгэсэн ажлын товч агуулгыг үндэслэл тус бүрээр бичнэ” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5, 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: ИТХ нь 2,367.4 мянган төгрөгийн, ЗДТГ нь 28,255.6 мянган төгрөгийн зэрэг нийт **30,622.9** мянган төгрөгийн шатахууны зардлыг жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн эхний, эцсийн заалтыг гүйцэтгэлээр бүртгэлгүйгээр батлагдсан маршрутын километрээр хянаагүй, бөөн дүнгээр бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар “Маягт заавар батлах тухай” тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шатахуун зарцуулалтын гүйцэтгэлийг жолоочийн тооцооны хуудсаар хянаж, анхан шатны баримтад үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗДТГ нь Өмч хамгаалах зөвлөлөөр автомашинд засвар, үйлчилгээ зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаарх техникийн комиссын дүгнэлт гаргалгүйгээр **10,413.3** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл, тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд үнэн зөв тусгаж байх.

3. Хоршоог хөгжүүлэх сантай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Санхүүгийн тайланд ХХС-аас олгосон зээлийн авлагад бүртгэлтэй 2011-2018 онд олгосон хугацаа хэтэрсэн 16 иргэний **54,631.6** мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг барагдуулахаар холбогдох шатны шүүхэд хандаж, шийдвэрлүүлэх арга хэмжээ аваагүй, зээл төлүүлэх мэдэгдэх хуудас өгөөгүй байгаа нь зээлийн үлдэгдэлд найдваргүй авлага үүсэх, ХХС-ийн эргэлтийг удаашруулах, эх үүсвэр дутагдах эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь зээлийн гэрээний 2.2 дахь “*Зээлийн үндсэн төлбөрийг дор дурдсан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлнө*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаж, ХХС-г хохиролгүй болгох.

3.2 Илрүүлэлт: Тайлант онд ХХС-аас олгосон Баялаг Зэлтэр хоршоо, Өгөөмөр түшиг өндөр хайрхан хоршоодод олгосон нийт **76,000.0** мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэх ажлын хэсэг байгуулаагүй, барьцаа хөрөнгө зээлийн дүнд хүрсэн эсэхийг үнэлэлгүйгээр олгосон байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.4 дэх “*Энэ журмын 3.4.3-т заасны дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулахдаа барьцаалах үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг тогтоох чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан дүгнэлт гаргуулах бөгөөд үл хөдлөх хөрөнгийг тухайн үеийн зах зээлийн үнэлгээний 70 хүртэл хувиар үнэлэх*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: ХХС-аас олгож байгаа зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээг холбогдох журмын үнэлэх ажлын хэсэг байгуулж, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ	1	17,150.0	1	17,150.0			1	17,150.0				
ЗДТГ	2	29,154.2	2	29,154.2			1	26,484.2	1	2,670	1	2,670
Дүн	3	46,304.2	3	46,304.2	-	-	2	43,634.2	1	2,670	1	2,670

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн						
ТТЗ	4	155,631.6			2	25,000.0	2	130,631.6				
ИТХ	2	13,997.3			1	11,629.9	1	2,367.4				
ЗДТГ	7	91,987.5			5	53,318.6	2	38,668.9				
Дүн	13	261,616.4	-	-	8	89,948.5	5	171,667.9				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ шилэн дансны цахим хуудаст 45 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	1				1			
ИТХ шилэн дансны цахим хуудаст 44 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	1				1			
ЗДТГ шилэн дансны цахим хуудаст 30 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	1				1			
Дүн	3				3			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТТЗ нь зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгааг урьдчилан хийгээгүй ТАХ-г ИТХ-аар батлуулж, хэрэгжүүлсэн	1	255,000.0			1	255,000.0		
ТТЗ нь байгууллагын урсгал зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой, ТАХ-г хэрэгжүүлсэн	1	8,000.0			1	8,000.0		
Дүн	2	263,000.0			2	263,000.0		
Нийт дүн	5	263,000.0			5	263,000.0		